

Онцгой дэглэм тогтоох асуудал ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага

Машлайн Алтан-Очир

Доктор (Ph.D), дэд профессор, төвийн эрхлэгч, altanochir99099@gmail.com
Монгол Улс, Улаанбаатар, Дотоод хэргийн их сургуулийн
Эрдэм шинжилгээний хүрээлэн

Хураангуй

Онцгой дэглэм тогтоох тухай асуудал бол тэр бүр хөндөгдөөд байдаггүй сэдэв бөгөөд тэр тусмаа амьдрал дээр хэрэгжүүлэх нь цөөн боловч нөхцөл байдал нь үүссэн үед зайлиггүй авах хойшлуулиггүй чухал арга хэмжээ, үйл ажиллагаа билээ. Энэхүү арга хэмжээ нь Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллагын мөрддөг хоёр хуульд тусгагдсан байдаг. Тодруулбал: Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль юм. Эдгээр хуульд заасан “Онцгой дэглэм тогтоох” тухай асуудал нь зайлиггүй хоёуланд нь байх ёстой юу? Эсвэл эрх зүйн давхцал уу? Аль нь болохыг тодорхой болгох үүднээс энэхүү бичил судалгааг хийсэн юм. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хууль, Онц байдлын тухай хууль болон холбогдох бусад хуулийг зайлиггүй судлан тэдгээрийн агуулга, утга санаатай хэрхэн нийцэж уялдаж байгааг тодруулах зорилгоор харьцуулан үзэж судлаачийн зүгээс үнэлэлт өгч, өөрийн саналаа илэрхийлсэн болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүрэг бүхий гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтад “Онцгой дэглэм тогтоох” асуудлыг хэрхэн тусгасан байгааг судлан үзсэн. Мөн дэглэм, онцгой дэглэм тогтоох гэж юу болохыг эрх зүйн онолын үүднээс тайлбарлан тодорхойлсон болно.

Түлхүүр үг: Үндсэн хуулийн эрх зүй, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй, дэглэм, хорих ял эдлүүлэх дэглэм, онц байдал, онцгой дэглэм

Оршил

Ардын хувьсгал 1921 онд ялснаас хойш өнөөг хүртэл хууль тогтоох байгууллагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиглэлээр найман удаагийн хуулийг батлан хэрэгжүүлж ирсэн бөгөөд 1966 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд зааснаар жирийн, чанга, онцгой, гяндан гэсэн дэглэм бүхий (колони) хорих ангид хорих ял эдлүүлэх ажиллагааг 2017 он хүртэл хэрэгжүүлж иржээ. “Онцгой дэглэмтэй хорих анги” болон “Хорих ангид онцгой дэглэм тогтоох” гэсэн ойролцоо утгатай мэт боловч ялгаатай хоёр ойлголт байгааг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Тодруулбал: Дээр дурдсан дөрвөн шатлал бүхий дэглэмийн хүрээнд 1966-2017 оны хооронд хорих ял шийтгүүлсэн этгээдийн ялыг эдлүүлж ирсний нэг нь “Онцгой дэглэмтэй хорих анги” бөгөөд 2017 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

тухай хуулиар хорих байгууллага нээлттэй, хаалттай дэглэмийн тогтолцоонд шилжсэнээр дуусгавар болсон юм. Харин “Хорих ангид онцгой дэглэм тогтоох” асуудлыг 2017 оны энэхүү хуульд шинээр тусгасан байна.

Хорих ангид онцгой дэглэм тогтоох асуудал нь тодорхой үндэслэл, тохиолдол бий болсон үед хэрэгжүүлдэг шуурхай арга хэмжээ юм. Өөрөөр хэлбэл: Тухайн хүндэрсэн цагийн байдалтай уялдуулан холбогдох хууль, журмын хүрээнд удирдлагын оновчтой шийдвэр гаргах, хүндэрсэн нөхцөл байдлыг даван туулахын тулд шаардлагатай төсөв, хүч, хэрэгслийг ашиглах, эрх бүхий байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллаж, асуудлыг шийдвэрлэн хэвийн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа юм. Ийм үед ойлгомжтой, тодорхой эрх зүйн орчныг бүрдүүлсэн байх нь хамгийн чухал асуудлын нэг бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Онц байдлын тухай хууль, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг харьцуулан судалж үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон болно.

Нэг. Дэглэмийн тухай ойлголт

Дэглэм нь оросоор-“режим”, францаар-“régime” латинаар-“regimen” гэж бичиж “дэглэм” гэсэн утгаар орчуулагддаг. Харин Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар тольд “Дэглэм-журам, зарчим, хэв заншил” (Цэвэл. Я, 1966) гэж тайлбарласан байна. Өнөөгийн нийгмийн амьдралын дунд дэглэм гэж юу болох хаана ямар хүрээнд юунд ашигладаг тухай тодорхой тогтсон мэдлэг, дэлгэрэнгүй мэдээлэл хомс байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Энэ ойлголтыг хүмүүс тэр бүр мэдэхгүй мэт боловч өдөр тутмын амьдралдаа хэрэглэж байдгийг анзаардаггүй байна. Тухайлбал: Эмчийн бичиж өгсөн жор түүнд тухайн эмийг яаж хэрхэн хэрэглэх тухай зайлшгүй баримтлах ёстой заавар, өдрийн дэглэм буюу тухайн хүний өдрийн туршид зайлгүй хийж гүйцэтгэдэг ажил үйлчилгээ, цагийн хувиар, хоолны дэглэм, түүнчлэн эрх зүйн дэглэм (Чимэд. Б, 2006, хууд. 31), улс төрийн дэглэм (Чимэд. Б, 2006, хууд. 33), ардчилсан дэглэм (Чимэд. Б, 2006, хууд. 34), тоталитар дэглэм (Чимэд. Б, 2006, хууд. 27) зэргээр цааш үргэлжилж болно.

Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимэд “Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр” номдоо “Тоталитар дэглэм гэдэг бол нэгэн бүлэг хүмүүс ихэнхдээ нэг намын удирдах бүлгийн гарт төвлөрч, улс төрийн сөрөг хүчин байх ардчилсан эрх чөлөө, боломжийг хааж хүн амын оюун санааны талаар нэг үзэлд шахан боолчилж, цэрэг цагдаагийн албадлага, хүчирхийллийн аргаар нийгмийг бүхэлд нь өөрсдийн ашиг сонирхолд зохицуулан, эрх мэдлээ хэрэгжүүлдэг улс төрийн дэглэм гэж үздэг” хэмээн тодорхойлсон байна.

Монгол Улсын Их хурлаас баталсан хүчин төгөлдөр үйлчилж буй 19 хуульд “хорио цээрийн дэглэм, хилийн дэглэм, хорих ял эдлүүлэх дэглэм, тусгай дэглэм” гэх мэт 15 төрлийн дэглэмийг хуульчилсан боловч тэдгээрийг нэр томьёоны хувьд тэр бүр тайлбарлан тодорхойлоогүй байна.

“Дэглэм гэж тодорхой цаг хугацаа, газар оронд тусгайлан зайлшгүй хэрэгжүүлэхээр тогтоосон эрх зүйн журам юм” (Алтан-Очир. М, 2020, р. 49).

Хоёр. Үндсэн хуульд заасан онцгой нөхцөл байдлын тухай

Монгол Улсын Үндсэн хуульд “Онц байдал зарлах” тухай заасан байдаг. Тодруулбал: Үндсэн хуулийн 25.2 дугаар зүйлд зааснаар дараах онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно.

1. Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;
2. Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон” (Монгол Улсын Их Хурал, 1992).

Эдгээрийг “онцгой нөхцөл” гэж үзэх бөгөөд ийм нөхцөл бий болсон үед Монгол Улсын Ерөнхийлөгч дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд: “Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно” (Монгол Улсын Их Хурал, 1992) гэж заажээ.

Дээрхээс үзвэл онц байдал зарлаж байгаа гол шалтгаан нь:

1. Хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;
2. Нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон үед Ерөнхийлөгчийн зарлигаар онц байдал зарлахаар зохицуулсан байна.

Үндсэн хуульд зааснаар онцгой нөхцөл үүссэн үед онц байдал зарлахаар хуульчилсан байх ба онцгой нөхцөл, онц байдал гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна.

Гурав. Бусад хуульд заасан онцгой дэглэмийн тухай

Онц байдлын тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд онцгой дэглэм тогтоох талаар заасан байдаг.

Онц байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлд: “Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор энэ хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэмийг онц байдал гэнэ” (Монгол Улсын Их Хурал, 1995) гэж тодорхойлсон байна. Үүнээс үзвэл онц байдал, онцгой дэглэм гэдэг нь нэг утга санааг илэрхийлэхээр хуульд заажээ.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд “Онцгой дэглэм тогтоох” тухай заасан. Уг хуулийн 42 дугаар зүйлд “Дараах таван тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (ШШГЕГ)-ын дарга Улсын ерөнхий прокурор (УЕП)-той зөвшилцөн 30 хүртэл хоногийн хугацаагаар хорих байранд онцгой дэглэм тогтоож болно.

1. Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон;
2. Тахал, гоц халдварт бусад өвчин болон их хэмжээний түймэр гарсан;
3. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон;
4. Хорих байранд зэвсэглэн халдсан;
5. Бусад” гэж заасан.

Хоригдсон этгээд болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд шууд аюул тулгарсан онцгой тохиолдолд хорих байрны дарга хоригдсон этгээдийн оролцоотойгоор зохион байгуулдаг бүх ажиллагааг зогсоож, хүч нэмэгдүүлсэн хамгаалалт тогтоох, эргэлт, уулзалт, захидал харилцааг хориглон хуульд заасан бусад шаардлагатай арга хэмжээг шуурхай авч, энэ тухайгаа ШШГЕГ-ын даргад нэн даруй мэдэгдэхээр заасан. Мөн 42.4-т “Хорих байранд тогтоосон онцгой дэглэмийг түүнийг тогтоосон албан тушаалтан, эсвэл эрх бүхий дээд шатны байгууллага, албан тушаалтан цуцална” (Лхагва. А, 2013, р. 222) гэж заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 249 дүгээр зүйлд хорих ангид онцгой дэглэм тогтоох тухай заасан байна. Тухайлбал: хорих ангид дараах тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын шийдвэрээр 30 хүртэл хоногийн хугацаагаар онцгой дэглэм тогтоож болно. Үүнд:

1. Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон;
2. Тахал, гоц халдварт болон олон улсын хөл хориот өвчин гарсан;
3. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон;
4. Хорих байгууллагад зэвсэглэн халдсан.

Хорих ангид тогтоосон онцгой дэглэмийг түүнийг тогтоосон албан тушаалтан цуцлах бөгөөд эдгээр үндэслэл арилаагүй тохиолдолд 30 хүртэл хоногоор сунгаж болно гэж заажээ.

Дөрөв. Харьцуулалт

Хорих байранд онцгой дэглэм тогтоох асуудлыг “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх” тухай хуульд заасан нь зөвхөн цагдан хорих байруудад хамаарах асуудал юм. Өөрөөр хэлбэл: ШШГЕГ-ын харьяа цагдан хорих чиг үүрэг хэрэгжүүлдэг нэгж байгууллагуудад хамаарахаар заасан байна. Ийм чиг үүрэг бүхий байгууллага Улаанбаатар хотод нэг буюу 461 дүгээр анги Хан-Уул дүүрэгт, IV цахилгаан станцын ойролцоо байрлах бөгөөд гамшиг, аюулт үзэгдэл, тахал, гоц халдварт өвчин, их хэмжээний түймэр гарсан тохиолдолд тухайн орчны нутаг дэвсгэрийг хамарч бусад байгууллага, иргэдэд аюул учруулах магадлалтай тул хил хязгаарыг нь шууд тогтоох боломжгүй. Энэ ангид онцгой дэглэм тогтоосноор асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй, зөвхөн энэ ангийн асуудал биш болж хувирна.

Хөдөө орон нутагт “хорих анги, цагдан хорих байр” нь нэг бүтцэд багтан үйл ажиллагаа явуулж байгаа цөөнгүй төвлөрсөн байгууллага бий. Тухайлбал: Багануур, Хэнтий, Ховд, Дархан, Орхон зэрэг аймагт байрлах шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, анги байгууллагыг нэрлэж болно. Эдгээрт дээрх нөхцөл байдал бий болсон тохиолдолд “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх” хуулийн дагуу зөвхөн цагдан хорих байранд нь “онцгой дэглэм” тогтоох уу? гэсэн асуулт гарч байгаа юм. Иймд дараах хуулиудыг харьцуулан авч үзье.

1. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль (СЯБЦХШБТХ), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд (ШШГТХ) заасан онцгой дэглэм тогтоох үндэслэл (тохиолдол)-ийн харьцуулалт.

Хүснэгт 1.

СЯБЦХШБТХ-д заасан онцгой дэглэм тогтоох үндэслэл	ШШГТХ-д заасан онцгой дэглэм тогтоох үндэслэл
Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон;	Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон;
Тахал, гоц халдварт бусад өвчин болон их хэмжээний түймэр гарсан;	Тахал, гоц халдварт болон олон улсын хөл хориот өвчин гарсан;
Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон;	Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон;
Хорих байранд зэвсэглэн халдсан;	Хорих байгууллагад зэвсэглэн халдсан;
Бусад	0
СЯБЦХШБТХ 1999 онд батлагдсан;	ШШГТХ 2017 онд батлагдсан;
Онцгой дэглэм тогтоох эрх бүхий субъект: ШШГЕГ-ын дарга УЕП-той зөвшилцөн...	Онцгой дэглэм тогтоох эрх бүхий субъект: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга...
Хугацаа: 30 хоног	Хугацаа 30+30 буюу 60 хоног

Онцгой дэглэмийг цуцлах эрх бүхий субъект: Түүнийг тогтоосон албан тушаалтан, эсвэл эрх бүхий дээд шатны байгууллага, албан тушаалтан цуцална.

Онцгой дэглэмийг цуцлах эрх бүхий субъект: Түүнийг тогтоосон албан тушаалтан цуцална.

Эндээс дүгнэх нь:

Энэ хоёр хуулийн харьцуулалтаас үзвэл онцгой дэглэм тогтоох үндэслэл нь ижил бөгөөд онцгой дэглэм тогтоох субъектийн хувьд СЯБЦХШБТ хуульд Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн шийдвэр гаргаж байгаагаар, мөн цуцлах эрх бүхий субъект нь дээд шатны байгууллага, албан тушаалтан байхаар заасан нь онцлог харагдаж байна. Хугацааны хувьд ШШГТХ-д 30 хоног нэмж сунгахаар заасан нь өөр боловч агуулгын хувьд эдгээр хуулийн харьцуулсан заалтууд нь адилхан гэж дүгнэж байна. Энд хорих байранд онцгой дэглэм тогтоох, хорих ангид онцгой дэглэм тогтоох гэсэн хоёр ойлголт явж байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

Түүнээс гадна онцгой дэглэм тогтоох дээрх үндэслэлд хорих ангиас олноороо бүлэглэн оргох, бусдыг барьцаанд авах, хэт давран өлсгөлөн, суулт зарлах, барьцаанд авах, хорих ангийн захиргаанд захирагдахгүй байх, хорих ангийг эзлэн авах тухай тусгагдаагүй байна. Хорих ангиудад гарч байсан ноцтой асуудал, цусаар бичигдсэн түүх, сургамж жишээ олон бий. Тухайлбал: 1980 онд Мааньт дахь “Чанга дэглэмтэй хорих анги”-аас есөн хоригдол бүлэглэн оргосон асуудал, 1995 онд Авдрантын гяндангаас таван хоригдол бүлэглэн оргож хүчин, хүн амины болон хүн, тээврийн хэрэгсэл барьцаалах гэмт хэрэг үйлдсэн нь тухайн үедээ нийгмийг цочроосон томоохон үйл явдлууд болж байв. Харин байгалийн гамшигт үзэгдлийн хувьд 2008 онд Хэнтий аймагт болсон хоёр хоног үргэлжилсэн үер хорих анги, цагдан хорих байранд хоригдож байсан олон хоригдогч нарын амь насанд аюул учруулах хүнд нөхцөл байдлыг бий болгосон байдаг.

Эдгээр хуулийг хэрэгжүүлэгч гол субъект нь ШШГБ бөгөөд дээрх дүгнэлттэй холбоотойгоор энэ мэт эрх зүйн давхардлыг арилгах үүднээс СЯБЦХШБТ хууль дахь заалтыг хүчингүй болгох, ШШГТХ-ын дээрх зүйл заалтыг дахин боловсруулж таваас дээш тооны хоригдол болон цагдан хоригдож буй этгээд бүлэглэн оргох, бусдыг барьцаанд авах, хорих ангийн захиргаанд захирагдахгүй байх, хорих ангийг эзлэн авах тухай асуудлыг нэмж оруулах, СЯБЦХШБТ хуультай уялдуулах нь зүйтэй гэж үзэж байна.

2. Онц байдлын тухай хуулийн холбогдох заалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн “Хорих ангид онцгой дэглэм тогтоох” заалттай харьцуулан үзье.

Хүснэгт 2.

Онц байдлын тухай хууль	ШШГ хууль, Хорих ангид онцгой дэглэм тогтоох тухай заалт
<u>Үндэслэл:</u> Хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц - Гамшиг; - Аюулт үзэгдэл; - Осол тохиолдсон; - Нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон.	<u>Үндэслэл:</u> - Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон; - Тахал, гоц халдварт болон олон улсын хөл хориот өвчин гарсан; - Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон; - Хорих байгууллагад зэвсэглэн халдсан
<u>Нутаг дэвсгэр:</u> Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт	<u>Нутаг дэвсгэр:</u> Хорих ангид
<u>Хугацаа:</u> Онц байдал үргэлжлэх хугацааг Улсын Их Хурал тогтооно. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн саналыг үндэслэн УИХ онц байдал зарлахад хүргэсэн нөхцөл бүрэн арилаагүй тохиолдолд сунгана, эсвэл хугацаанаас нь өмнө цуцална.	<u>Хугацаа:</u> 30 хүртэл хоног, үндэслэл арилаагүй тохиолдолд 30 хүртэл хоногоор сунгаж болно.
<u>Шийдвэр гаргах субъект:</u> Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл УИХ -ын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүйн санаачилгаар хэлэлцэж шийдвэрлэнэ.	<u>Шийдвэр гаргах субъект:</u> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга онцгой дэглэм тогтоох буюу цуцална.
<u>Удирдан зохион байгуулах субъект:</u> Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	<u>Удирдан зохион байгуулах субъект:</u> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга
<u>Удирдан зохион байгуулах субъектийн эрх хэмжээ:</u> Зөвлөлийн онцгой 16 төрлийн бүрэн эрхийг тусгасан.	Зохицуулаагүй
<u>Засаг даргын онцгой бүрэн эрх:</u> Засаг даргын есөн төрлийн бүрэн эрхийг хуульчилсан байна.	Зохицуулаагүй
<u>Бүрэн эрхт төлөөлөгчийн онцгой бүрэн эрх:</u> Бүрэн эрхт төлөөлөгчийн зургаан төрлийн бүрэн эрхийг тусгасан.	Зохицуулаагүй

<u>Онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгахад цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулах:</u> Нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллагын хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд... зэвсэгт хүчин, хилийн цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулж болно.	Зохицуулаагүй
<u>Онц байдлын арга хэмжээг санхүүжүүлэх:</u> Онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгахтай холбогдсон арга хэмжээг Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэх бөгөөд шаардлагатай асуудлыг Засгийн газар УИХ-д оруулж шийдвэрлүүлнэ.	Зохицуулаагүй
<u>Онц байдлын үед хэрэгжүүлэх онцгой арга хэмжээ:</u> 16 дугаар зүйл. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр онц байдал тогтоосон бол дор дурдсан онцгой арга хэмжээ тогтоож болно: Үүнд есөн төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр; 1. 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн есөд заасны дагуу тогтоох тусгай дэглэм нь дор дурдсан хүрээгээр хязгаарлагдана: Үүнд: найман арга хэмжээ; 2. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т заасан үндэслэлээр онц байдал зарласан бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дор дурдсан нэмэлт онцгой арга хэмжээ тогтоож болно: Үүнд есөн төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус заасныг хураангуйлсан болно.	Хорих ангид онцгой дэглэм тогтоох үед хэрэгжүүлэх онцгой арга хэмжээ: • Хорих ангийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг нэмэгдүүлж, • хорих ангийн өдрийн цагийн хуваарийг өөрчилж болно.
<u>Онц байдлын үед иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах хүрээ:</u> Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээ зааг нь бий болсон онцгой нөхцөлийн шаардлага, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгт нийцэж байхаас гадна хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байвал зохино.	<u>Хорих ангид онцгой дэглэм тогтоох үед хоригдлын эрхийг хязгаарлах хүрээ:</u> Хоригдлын оролцоотой зохион байгуулагддаг бүх ажиллагааг зогсоох эргэлт, уулзалт, захидал харилцааг хориглох

<u>Онц байдлын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага:</u> 1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Зохицуулаагүй
--	----------------------

Эндээс дүгнэх нь: Дээрх хоёр хуулийн харьцуулалтаас үзэхэд “Хорих ангид онцгой дэглэм тогтоох” асуудал нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд анх удаа тусгагдсан боловч олон асуудлыг зохицуулаагүй орхигдсон учир дутагдалтай байгаа нь харагдаж байна. Зохицуулаагүй орхигдсон зүйлүүд нь “Онц байдлын тухай” хуультай заавал адилхан байх шаардлагагүй ч тэдгээрт тохирсон чиг үүрэг, эрх хэмжээ, санхүүжилт, хариуцлага түүнийг хэрэгжүүлэх субъектийг тусгах нь зүйтэй юм.

“Онцгой дэглэм тогтоох” тухай нэр томъёог тодорхойлсон тайлбар дээрх хуулиудад байхгүй тул түүнийг дэглэмийн ерөнхий ойлголт, агуулгын хүрээнд дараах байдлаар тодорхойлов.

Онцгой дэглэм тогтоох гэдэг нь эрх бүхий байгууллага албан тушаалтнаас хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тодорхой цаг хугацаа, газар орон, субъектүүдэд онцгойлон зайлшгүй хэрэгжүүлэхээр тогтоосон эрх зүйн горим журам юм (Алтан-Очир. М, 2020, р. 181). Онцгой дэглэм тогтоох үндэслэл нь:

- Байгалийн давагдашгүй хүчин (Салхи, үер, газар хөдлөлт, аянга, гал түймэр г.м), аюулт үзэгдэл;
- Тахал, гоц халдварт болон хөл хориот өвчин гарсан (Хүн, мал амьтны),
- Гамшиг, осол, гэнэтийн бусад аюул тохиолдсон;
- Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон;
- Зэвсэгт үймээн (Доржня. Ц. Цогтоо. М, 2016, хууд. 69), терроризм (Доржня. Ц. Цогтоо. М, 2016, хууд. 144), хорлон сүйтгэх (Доржня. Ц. Цогтоо. М, 2016, хууд. 211) ажиллагаа гэх мэт байж болно.

Тав. Гадаадын зарим орны онцлог

ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 85 дугаар зүйлд “хорих ангид онцгой дэглэм тогтоох” тухай заасан байдаг. (Уголовно-исполнительный кодекс Российской Федерации (Плюс, 1997) от 8.1.1997 Статья 85. “Режим особых условий в исправительных учреждениях”) Үүнд: Байгалийн гамшиг, нийтийн эмх замбараагүй байдал, хоригдол бүлэглэн хорих ангийн захиргаанд захирагдахгүй байх тохиолдолд холбооны гүйцэтгэх засаглалын удирдлагаас хууль хэрэгжүүлэх, хоригдлын харилцаа

болон эрүүгийн ял эдлүүлэх хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийнхээ хүрээнд, эсхүл ОХУ-ын Ерөнхий буюу холбогдох прокурортой зөвшилцөн ОХУ-ын бүс нутгийн хорих байгууллагын даргын шийдвэрээр 30 хоногийн хугацаагаар онцгой дэглэм тогтоох, дайны байдалд шилжих ба цаашид үргэлжлэхээр бол эрх бүхий этгээдийн шийдвэрээр хуульд заасны дагуу 30 хоногоор сунгахаар заасан байна.

Онцгой дэглэм тогтоосон үед хүч нэмэгдүүлсэн хамгаалалтад шилжиж, онцгой журам тогтоож хяналт тавих ба өдрийн цагийн хуваарийг өөрчилж, хоригдлын хэд хэдэн эрхийг хуульд заасны дагуу хязгаарлахаар заажээ. Үүнд: Эрүүл ахуй, ариун цэврийн хэрэглээнээс бусад үйлдвэрлэл, гэр бүлтэйгээ уулзах, соёл, боловсрол, үйлчилгээний үйл ажиллагааг хязгаарлахаар заажээ.

Зургаа. Ерөнхий дүгнэлт, санал

Хорих байгууллагад онцгой дэглэм тогтоох асуудлыг тусгай журмаар зохицуулдаг хэдий ч салбарын гол хуульд нарийвчлан тусгаснаар удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд үндсэн суурь нь болж өгдөг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Хорих ангид онцгой дэглэм тогтоох” асуудал нь шинээр тусгагдсан боловч олон асуудлыг зохицуулаагүй учир дутагдалтай байгаад дүгнэлт хийж нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Энэхүү нэмэлт өөрчлөлтийг хийхдээ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэг хүний эрх, эрх чөлөө болон 25.2 дугаар зүйл онц байдал зарлах тухай заалт, Онц байдлын тухай хуулиудад нийцүүлэн боловсруулах;
2. Хүний эрхийн чиглэлээр олон улсын байгууллагаас гаргасан баримт бичиг /зарчим, зөвлөмж, дүрэм, факт, конвенц/-ийг судлан уялдуулах;
3. Гадаадын зарим орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын туршлагыг судлах.

Түүнчлэн ШШГТХ-ийн хорих ангид онцгой дэглэм тогтоох тухай /249/ зүйлийг дахин боловсруулж, таваас дээш тооны хоригдол болон цагдан хоригдож буй этгээд бүлэглэн оргох, бусдыг барьцаанд авах, нийтээрээ болон тодорхой бүлэг хорих ангийн захиргаанд захирагдахгүй байх, хорих ангийг эзлэн авах тухай асуудлыг нэмж оруулах, Онцгой дэглэм тогтоох үеийн эрх бүхий субъектийн эрх зүйн байдал /чиг үүрэг, эрх хэмжээ/, нутаг дэвсгэрийн хамаарал, санхүүжилт, хоригдлын эрхийг хязгаарлах хүрээ, хариуцлагын талаар тусгахын зэрэгцээ сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн /Хорих байранд онцгой дэглэм тогтоох/ 42 дугаар зүйлийг бүхэлд нь хүчингүй болгох нь зүйтэй юм.

Эх сурвалжийн жагсаалт

Алтан-Очир. М. (2020). Хорих ял эдлүүлэх дэглэм. Улаанбаатар.

Доржням.Ц., Цогтоо.М. (2016). Аюулгүй байдлын нэр томъёоны тайлбар толь. Улаанбаатар.

Лхагва. А. (2013). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж. Улаанбаатар.

Плюс, w. О. (1997). www.consultant.ru Официальный сайт компании «Консультант Плюс. www.consultant.ru.

УИХ, (1992 оны 01 13). Монгол Улсын Үндсэн хууль. Эрх зүй мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367-ээс>

УИХ, (1995 оны 11 14). Онц байдлын тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=433-ээс>

Цэвэл. Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар.

Чимэд. Б. (2006). Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. Улаанбаатар.

Emergency State Establishment Issues and Court Decision Enforcement Organizations

Altan-Ochir Mashlai

Doctor (Ph.D), Associate professor, Head of Center, altanochir99099@gmail.com
Research Institute of the University of Internal Affairs, Mongolia,
Ulaanbaatar, Mongolia

Abstract

The issue of establishing a state of emergency is a topic that is not often discussed, primarily because it is rarely implemented in practice, yet it is an important and urgent measure that must be taken when emergencies arise. This measure is reflected in two laws that govern the Mongolian court enforcement agency. These are: The Law on the Execution of Decisions on the Arrest and Detention of Suspects and the Accused, and the Law on the Execution of Court Decisions. Does the issue of “Establishing a Special Regime” specified in these laws necessarily apply to both? Or is there a legal overlap? This micro-study was conducted to clarify which is which. In this regard, this article examines the Constitution of Mongolia, the Law on the State of Emergency, and other relevant laws to clarify their content and meaning, and compared them to provide assessments and opinions. It also examines how the issue of “establishing a special regime” is reflected in the legal regulations for enforcing court decisions of some foreign countries. Finally, the article explains and defines what constitutes establishing a regime and a special regime from the perspective of legal theory.

Keywords: Constitutional law, Criminal enforcement law, Regime, Regime for Serving prison sentences, State of Emergency, Special regime.

Received: September 10, 2025 | Accepted: September 15, 2025 | Published online: October 13, 2025



© The Author(s) 2025
<http://creativecommons.org/licenses/by/4.0/>.